

**ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2024 оны 02 сарын 01

Дугаар 07/2024

Улаанбаатар хот

НЭГ. Ерөнхий хэсэг

1.1. Барилга байгууламжийн нэр, байршил, хүчин чадал:

Монгол улсын төсвөөр хэрэгжиж буй Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Тавантолгойн Нүүрс Ачих Логистикийн Төв” төслийн гадна цахилгаан хангамжийн багц ажлын хүрээнд шинээр барьж байгуулсан 35кВ-н хоёр хэлхээ 0,9км цахилгаан дамжуулах агаарын шугам болон 35/6кВ-ын 4000 кВА дэд станц, 35/0,4кВ-ын 3150 кВА, 2х2500 кВА дэд станцууд, 110/35/6кВ-н 2х40 МВА чадалтай Цанхи дэд станцын өргөтгөл болон 35 кВ, 6кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам.

1.2. Хөрөнгө оруулагчийн нэр, хаяг:

“Эрдэнэс Тавантолгой” ХК Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо. Жигжиджавын гудамж-8 Финанс төв

“Тавантолгой Төмөр Зам” ХХК Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, /14230/ Нарны зам-62, Юнион Бюлдинг, Б блок, 11 давхар
Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Сийрст баг – Тавантолгой өртөө

1.3. Ашиглагч аж ахуй нэгж, байгууллага:

Эрдэнэс Тавантолгой ХК, Тавантолгой Төмөр Зам ХХК

1. 110/35/5 кВ-ын 2х40 МВА чадалтай “Цанхи” дэд станцын өргөтгөл
2. 35кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам
3. 35/6 кВ-ын 4000 кВА чадалтай “ТНАЛТ”- дэд Станц
4. 35/0.4 кВ-ын 3150, 2х2500 кВА чадалтай “ТНАЛТ-1,2,3” дэд станц
5. 6/0.4 кВ-ын 1000 кВА чадалтай “КТПН-01” дэд станц
6. 35 кВ болон 6 кВ-ын Цахилгаан дамжуулах кабель шугам

1.4. Ерөнхий болон туслан гүйцэтгэгчийн нэр хаяг:

Ерөнхий гүйцэтгэгч: Бодь Интернэшнл ХХК Улаанбаатар хот, 14241 Чингисийн өргөн чөлөө-24, Парк плейс оффис

Туслан гүйцэтгэгч: Монхорус Интернэшнл ХХК Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Магнолиа оффис.

Зураг төсөл зохиогчийн нэр, хаяг:

1. Шугам ХХК, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Гутал оффис, 501 тоот

- 1.5. Монгол улсын төсвөөр хэрэгжиж буй Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Тавантолгойн Нүүрс Ачих Логистикийн Төв” төслийн гадна цахилгаан хангамжийн багц ажлын хүрээнд шинээр барьж байгуулсан 35кВ-н хоёр хэлхээ 0,9км цахилгаан дамжуулах агаарын шугам болон 35/6кВ-н дэд станц, 35/0,34кВ-н дэд станцууд, 110/35/6кВ-н Цанхи дэд станцын өргөтгөл болон 35кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугамын төслийн ажлын гүйцэтгэл, ажлын чанар, холбогдох акт, баримтуудтай танилцаад газар дээр нь үзлэг, шалгалт хийв.
- 1.6. Энэхүү барилга байгууламжийг 2022.03.23-нд гарсан 47/2022/252/НӨ дугаартай техникийн нөхцөлийн дагуу 2023/ц-6 ажлын даалгавраар, “ДҮТ” ТӨХХК 2022.02.20 дугаартай горимын тооцооны дагуу Зураг төсөл зохиогч “Шугам” ХХК-н зураг төслөөр 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс барьж эхэлсэн ба 2023 оны 05 дүгээр сарын 22-ны өдөр барьж дууссан байна.

ХОЁР. Дүгнэлтийн хэсэг

- 2.1. Энэхүү Монгол улсын төсвөөр хэрэгжиж буй Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Тавантолгойн Нүүрс Ачих Логистикийн Төв” төслийн гадна цахилгаан хангамжийн багц ажлын хүрээнд шинээр барьж байгуулсан 35кВ-н хоёр хэлхээ 0,9км цахилгаан дамжуулах агаарын шугам болон 35/6кВ-н дэд станц, 35/0,34кВ-н дэд станцууд, 110/35/6кВ-н Цанхи дэд станцын өргөтгөл болон 35кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугамын төслийн хэрэгжсэн барилга байгууламж, холбогдох баримт бичигт үзлэг хийж, ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэхүү эрчим хүчний барилга байгууламжийн ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд холбогдох мэргэжлийн байгууллагаар шийдвэр гаргуулан 110/35/5 кВ-ын 2х40 МВА чадалтай “Цанхи” дэд станцын өргөтгөл, 35кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, 35/6 кВ-ын 4000 кВА чадалтай “ТНАЛТ”- дэд Станц, 35/0.4 кВ-ын 3150, 2х2500 кВА чадалтай “ТНАЛТ-1,2,3” дэд станц, 6/0.4 кВ-ын 1000 кВА чадалтай “КТПН-01” дэд станц, 35 кВ болон 6 кВ-ын Цахилгаан дамжуулах кабель шугамын цахилгаан хангамжийн барилга байгууламжийн ашиглалтыг “Тавантолгой Төмөр зам” ХХК-ийн мэдэлд 2023 оны 12-р сарын 01-ны өдрөөс ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

2.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- А) Барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивд, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч байгууллагад ~~1.4~~ хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- Б) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг ашиглалтыг хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

2.3. Ашиглагч байгууллагад:

- а) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) Барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх, баяжилт хийж байх;
- в) Барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, засвар үйлчилгээг тогтоосон хугацаанд тогтмол хийж ажиллахыг үүгээр даалгаж байна.


2.4. Улсын комиссын акт 5. хуудас, хурлын тэмдэглэл 4. хуудас, Улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 2. хуудас материал, барилга байгууламжийн баримт бичгийн жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

ГУРАВ. Дүгнэлтийн баталгаажуулалт

3.1. “Тавантолгойн Нүүрс Ачих Логистикийн Төв” төслийн гадна цахилгаан хангамжийн багц ажлын хүрээнд шинээр барьж байгуулсан 35кВ-н хоёр хэлхээ 0,9 км цахилгаан дамжуулах агаарын шугам болон 35/6кВ-ын 4000 кВА чадалтай дэд станц, 35/0,4 кВ-н 3150 кВА, 2х2500 кВА чадалтай дэд станцууд, 6/0.4 кВ-ын 1000 кВА чадалтай дэд станц, 110/35/6кВ-н Цанхи дэд станцын өргөтгөл болон 35кВ, 6 кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугамын төслийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Комиссын дарга:

Г.Мөнхтөр



Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын цахилгааны хэлтсийн шинжээч

Комиссын гишүүд

П.Даваадорж



Эрчим хүчний яамны Салбарын хяналтын газрын ахлаач шинжээч, эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч

Р.Ширчинням

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

Ө.Учрал



Өмнөговь аймгийн Архивын тасгийн дарга, архив албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч

Б.Будсүрэн-2

Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч

Л.Батхүү

“Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-н Захиалагч, техник хяналтын хэлтсийн дарга

Д.Цэрэндамба

“Цахилгаан дамжуулах үндэсний төв” ТӨХК-н Говийн бүсийн салбарын Ерөнхий инженер

Б.Баярхүү

“Цахилгаан дамжуулах үндэсний төв” ТӨХК-н Говийн бүсийн салбарын реле хамгаалалт, автоматик хэмжилт туршилтын албаны дарга

С.Чулуунбаатар



“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ”-ийн хэмжүүрийн инженер

Б.Чинзориг

“Шугам” ХХК-н Гүйцэтгэх захирал бөгөөд Зургийн автор

Б.Алтангэрэл

“Тавантолгой Төмөр Зам” ХХК ТНАЛТ төслийн менежер

Д.Эрхэмбаяр

“Тавантолгой Төмөр Зам” ХХК Эрчим хүчний ашиглалтын инженер

Т.Даваадалай

“Бодь Интернэшнл” ХХК-н ТНАЛТ төсөл хариуцсан захирал бөгөөд Ерөнхий гүйцэтгэгч

Л.Билгүүндалай

“Бодь Интернэшнл” ХХК-н ТНАЛТ төсөл
цахилгаан, автоматжуулалтын ахлах
инженер бөгөөд Ерөнхий гүйцэтгэгч

С.Нэргүй

“Ти Ти Жи Ви Си Өү” ХХК цахилгаан
хэлтсийн инженер 110/35/6кВ-ын Цанхи дэд
станцын өмчлөгч

Х.Ариунболд



Энержи Интернэйшнл ХХК-н
Ерөнхий инженер 110/35/6кВ-ын Цанхи дэд
станцын ашиглалт, шуурхай үйлчилгээ
хариуцсан компани

Нарийн бичгийн дарга:

Ч.Оюунболд

“Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн
Захиалагч, техник хяналтын хэлтсийн
хяналтын инженер